


# ОЛОН НИЙТИЙН ЦАГДАА

“Нутгийн өөрөө удирдах байгууллага нь оршин суугч иргэд, цагдаагийн байгууллагын санал, хүсэлтийг үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн цагдаа ажиллуулж болно.”

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.



## НИЙСЛЭЛ БОЛОН 19 АЙМАГТ\*

# 389

ОЛОН НИЙТИЙН ЦАГДАА (ОНЦ) АЖИЛЛАЖ БАЙНА.

\* Төсөвгүйн улмаас Сэлэнгэ, Төв аймагт ОНЦ ажилладаггүй.

### АЖЛЫН НӨХЦӨЛ




### УРАМШУУЛАЛ

ОНЦ-ийн урамшууллыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл орон нутгийн төсөв, Засаг даргын нөөц сан зэргээс аймаг бүр өөрийн онцлогт тохируулан олгож байна.

**2017** Мониторингийн дүнгээр нийслэл, 15 аймгийн ОНЦ урамшуулал авчээ.


ОНЦ-ийн урамшуулал **60'000 - 355'000** төгрөгийн хооронд ялгамжтай байна.

### Нийслэл ба аймгуудын урамшууллын хэмжээ



Үйл ажиллагаа явуулахад учирч буй бэрхшээлийн тухай нийслэл болон 17 аймаг санал өгсөн.

Үүнд:



УРАМШУУЛАЛ  
БАГА



АЖЛЫН АЧААЛАЛ ИХ,  
ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ,  
ХАНГАМЖ МУУ



### ОНЦ-ийн хөдөлгөөн

Урамшуулал бага, ажлын ачаалал ихээх шалтаалж 1 сараас 1 жилийн хугацаанд ОНЦ өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх нь түгээмэл байна.



### Урамшуулал, ажлын хөлс

Урамшуулал бага, ээлжийн амралт, илүү цагийн хөлс олгодоггүй.



### Хөдөлмөр хамгааллын хувцас

Хүрэлцээ муу, чанаргүй, бүх улирлыг хамруулаагүй.



### Тусгай хэрэгсэл

17 аймгийн ОНЦ төсөвгүйн улмаас тусгай хамгаалах хэрэгслээр хангагдаагүй. Зарим тохиолдолд тэдгээрийг хувийн зардлаараа авдаг.

### Бусад

- Ажлын ачаалал их.
- Ажлаас гэнэт халагдсаны тэтгэмж олгодоггүй.
- Сургалтад хамруулах төсөвгүй.
- Шөнийн цагаар болон гэр хороололд ажиллахад нөхцөл хүнд.
- Унааны зардал, томиллолт олгодоггүй.
- Ажлын үнэмлэхгүй тул иргэд үл тоодог.
- Ажлын чиг үүрэг тодорхойгүй.

- Эргүүл, жижүүрийн ажлыг сайн гүйцэтгэдэг.
- Иргэд, цагдаагийн хооронд "гүүр" нь болдог.
- Цагдаагийн байгууллагыг мэдээллээр хангадаг.
- Үерийн уснаас сэргийлэх хоолой, шуудуунд хог хаяж буй иргэдэд торгууль ногдуулсан нь үр дүнтэй болсон.
- "Дугуйт цагдаа" хөтөлбөр хэрэгжүүлсэн.
- Сургууль, цэцэрлэгийг хамруулан аян зохион байгуулдаг.
- Иргэдэд сэрэмжлүүлэг өгдөг.
- Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг.

### ДҮРЭМД ОРУУЛАХ САНАЛ

14 аймаг ОНЦ-ийн дүрэмд оруулахаар өгсөн саналыг бүлэглэн харуулбал:



Төсвийг цогцоор шийдэх



Сургалтад тогтмол хамруулах



Хувцас, тусгай хэрэгслээр хангах



Ажиллах чиг үүргийг тодорхой болгох



Урамшууллыг нэмэх, илүү цагийн хөлсийг олгох



Аюулгүй байдлыг хангах



Тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг шийдэх



Олон нийттэй ажиллах чиг үүргийг тодорхой болгох